



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/154

Хажуу шинэ-Ус

Хагас жилийн мал тооллого
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн В, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/345 дугаар тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны хагас жилийн түүвэр мал тооллогын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Т.Ариунаа	(Сумын Засаг дарга)
Нарийн бичгийн дарга:	Н.Болор-Эрдэнэ	(Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)
Гишүүд:	Б.Мөнхдэлгэр	(1 дүгээр багийн Засаг дарга)
	М.Амарзаяа	(2 дугаар багийн Засаг дарга)
	Н.Энхтайван	(3 дугаар багийн Засаг дарга)
	Л.Батбаатар	(4 дүгээр багийн Засаг дарга)
	Д.Сарангэрэл	(Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэнг түр орлон гүйцэтгэгч)

2.Хагас жилийн түүвэр мал тооллогын ажлыг 05 дугаар сарын 27-с 06 дугаар сарын 04-ний дотор сонгогдсон өрхүүдэд явуулж нүд үзэн тоолж, тооллогын ажлыг чанартай үр дүнтэй явуулахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Мал тооллогын мэдээллийг программд шивж нэгдсэн дүнг аймгийн статистикийн хэлтэст 06 дугаар сарын 10-ний дотор тушаахыг Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн (Н.Болор-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.АРИУНАА

482401054